



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд АЗЗА ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2025/001/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2025 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Т.Бат-Эрдэнэ Утас:70432545 Цахим хаяг: Bat-erdenet@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЗЗА ТӨХК ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ С.САНСАРХҮҮ ТАНАА

2025.03.15 № 2/10

танай _____-ны № _____-Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу ХОВД АЗЗА ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус компани нь улсын чанартай 984,26 км зам, замын байгууламжийн бэлэн байдлыг зам хариуцагчийн гэрээгээр хариуцан ажилладаг бөгөөд 2024 онд улсын чанартай замын 5 чиглэлд засвар арчлалтын ажлыг тасралтгүй гүйцэтгэж замын бэлэн байдлыг ханган ажилласан.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудитадаар ихээхэн нөлөө үзүүлсэн дараах 2 ажил байна.

Ховд аймгийн төвд 1,8 км замын засвар шинэчлэлийн ажлын аргачлалыг өөрчлөн суурийг засварлан, халуун асфальт бетоноор хучилт хийсэн.

А14 дугаартай Манхан-Булган-Улсын хил чиглэлийн 356 км замын Хавчгийн хавцалд байгалийн гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс нөлөөлж түр зуурын аадар бороо орсны улмаас хавцлын нийтэд чулуу шороо урсан орж зам, замын байгууламжийг ихээхэн хэмжээгээр гэмтээсэн. Энэхүү эвдэрсэн замыг хуучин байдалд сэргээн засварласан.

Бусад асуудлын хэсэг

Азийн хөгжлийн банкны 3129-МОН зээлийн хөрөнгөөр “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх төсөл хөтөлбөр”-ийн хүрээнд нийлүүлэгдэж байгаа зам барилгын ажлын гол түүхий эд материалын үйлдвэр асфальт бетон завод, эмульсийн үйлдвэр, бутлуурын үйлдвэрийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор үйлдвэрийн бүсэд кадастрын зураг хийлгэсэн.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Төгрөгөөр

Үзүүлэлтийн нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	388,045,140.97	64,567,408.09
1.1.2. Дансны авлага	52,386,252.96	205,242,654.54
1.1.3. Татвар НДШ-ийн авлага	5,210,061.54	6,491,829.89
1.1.4. Бусад авлага	34,893,758.66	4,776,850.67
1.1.6. Бараа материал	820,166,269.05	405,845,748.23
1.1.7. Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	8,818,181.82	-
1.1.9. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	36,500,000.00	36,500,000.00
1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн	1,346,019,665.00	723,424,491.42
1.2. Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1 Үндсэн хөрөнгө	1,244,016,294.31	1,101,326,491.86
1.2.2 Биет бус хөрөнгө	229,444,000.00	231,604,000.00
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,473,460,294.31	1,332,930,491.86
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,819,479,959.31	2,056,354,983.28
2.1.1.1 Дансны өглөг	82,080,000.00	300,995,976.61
2.1.1.3 Татварын өр	5,498,858.77	15,927,115.98
2.1.1.8 Урьдчилж орсон орлого	410,853,054.70	-
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	498,431,913.47	316,923,092.59
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр	385,901,585.00	385,901,585.00
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн	385,901,585.00	385,901,585.00
2.2 Өр төлбөрийн нийт дүн	884,333,498.47	702,824,677.59
2.3 Эздийн өмч	78,052,800.00	78,052,800.00
2.3.1 Төрийн	78,052,800.00	78,052,800.00
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	77,664,398.45	77,664,398.45
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	1,585,552,939.76	1,576,598,939.76
2.3.9 Хуримтлагдсан ашиг	193,876,322.63	(378,785,832.52)
2.3.11 Эздийн өмчийн дүн	1,935,146,460.84	1,353,530,305.69
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,819,479,959.31	2,056,354,983.28

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	3,690,302,051.67	4,183,695,633.07
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,429,512,342.59	4,385,332,635.75
3. Нийт ашиг (алдагдал)	260,789,709.08	(201,637,002.68)
4. Түрээсийн орлого	-	-
5. Хүүний орлого	2,199,523.39	2,001,726.70
6. Ногдол ашгийн орлого	-	-
7. Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8. Бусад орлого	66,948,501.27	85,773,730.91
9. Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10. Ерөнхий ба удирдлагын зардал	277,768,866.92	359,427,725.41
11. Санхүүгийн зардал	-	-
12. Бусад зардал	40,062,965.04	97,847,004.66
13. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	2,090,909.09	-
15. Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16. Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17. Бусад ашиг (алдагдал)	-	-
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	14,196,810.87	(571,136,275.14)
19. Орлогын татварын зардал	4,024,280.71	-
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	10,172,530.16	(571,136,275.14)
21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагд)	-	-
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	10,172,530.16	(571,136,275.14)
23. Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	10,172,530.16	(571,136,275.14)
25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1.1 Мөнгөн орлогын дүн	4,621,036,790.00	3,963,065,347.00
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,473,897,231.00	3,776,250,224.00
Бусад мөнгөн орлого	147,139,559.00	186,815,123.00
1.2 Мөнгөн зарлагын дүн	4,498,497,786.25	4,277,951,026.58
Ажиллагчдад төлсөн	517,457,395.00	528,405,997.80
Нийгмийн даатгалын байгуулгад төлсөн	196,791,110.53	206,366,582.77
Бараа материал худалдан авахад төлсөн	1,761,644,541.17	1,031,690,429.00
Ашиглалтын зардал төлсөн	6,187,991.61	9,474,456.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,118,632,790.00	728,684,910.00
Хүүний төлбөрт төлсөн	-	8,498,630.14
Татварын байгуулгад төлсөн	209,837,775.58	252,271,972.11
Даатгалын төлбөрт төлсөн	7,122,103.00	-
Бусад мөнгөн зарлага	680,824,079.36	1,512,558,048.76
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	122,539,003.75	(314,885,679.58)
Мөнгөн орлогын дүн	4,499,523.39	2,001,726.70
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	2,300,000.00	-
Хүлээн авсан хүүний орлого	2,199,523.39	2,001,726.70
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Мөнгөн зарлагын дүн	54,220,000.00	9,067,900.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	54,220,000.00	5,767,900.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	3,300,000.00
2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(49,720,476.61)	(7,066,173.30)
Мөнгөн орлогын дүн		250,000,000.00
Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		250,000,000.00
Мөнгөн зарлагын дүн		251,525,880.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		250,000,000.00
Төлсөн ногдол ашиг		1,525,880.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(1,525,880.00)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	72,818,527.14	(323,477,732.88)
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	315,226,613.83	388,045,140.97
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	388,045,140.97	64,567,408.09

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

Д.д	Үндсэн үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 он		Харьцуулалт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувиар (2024 гүй/2023 төл)	Дүнгээр (2024гүй-2024төл)
А	Б	1	2	3	6	7
1	Нийт орлого	3,761,540,900	4,545,187,110	4,271,471,091	94	(273,716,019)
	Үүнээс: Улсын чанартай ЗЗА	3,328,028,000	3,835,612,800	3,372,784,091	88	(462,828,709)
	Бусад	433,512,900	709,574,310	898,687,000	127	189,112,690
2	Нийт зардал	3,747,344,100	4,487,343,000	4,842,607,366	108	355,264,366
	Үйл ажиллагааны зардалд	277,768,800	361,900,200	359,427,725	99	(2,472,475)
3	Татварын өмнөх ашиг	14,196,800	57,844,110	(571,136,275)	(987)	(628,980,385)
4	Цэвэр ашиг/ алдагдал/	10,172,500	52,059,710	(571,136,275)	(1,097)	(623,195,985)
5	Төсвийн төлбөрт	408,663,300	615,151,000	458,638,555	75	(156,512,445)
	а/Орлогын татварт	4,024,300	5,784,400	-	-	(5,784,400)
	б/НӨАТ	134,745,300	255,437,100	185,033,303	72	(70,403,797)
	в/НДШ	196,791,100	263,510,500	206,366,583	78	(57,143,917)
	г/ХАОТатварт	59,913,800	65,533,100	63,730,469	97	(1,802,631)
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татварт	1,142,000	1,500,000	621,090	41	(878,910)
	е/ТТАМАТ	8,004,800	16,016,300	-	-	(16,016,300)
	ё/Ус ашигласны төлбөр	368,200	-	191,061		191,061
	ж/Газрын төлбөр	1,399,600	1,399,600	203,000	15	(1,196,600)
	з/Тээврийн хэрэгслийн татварт	1,690,700	1,970,000	1,746,549	89	(223,451)
	и/Бусад татварт	583,500	4,000,000	746,500	19	(3,253,500)
6	Төрийн өмчийн ноогдол ашиг/2023 оныг тооцсон түвшин/	1,525,875	13,597,500	1,525,900	11	(12,071,600)
7	Нийт авлага	92,490,000	185,389,600	216,511,335	117	31,121,735
8	Нийт өглөг	884,333,500	542,752,385	702,824,678	129	160,072,293
	Үүнээс. 8.1 богино хугацаат	498,431,900	156,850,800	316,923,093	202	160,072,293
	8.2 Урт хугацаат өр төлбөр	385,901,600	385,901,585	385,901,585	100	-
9	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	1	1	1	115	0
10	Хөрөнгө оруулалт	54,220,000	165,000,000	9,067,900	5	(155,932,100)
11	Ажиллагсдын тоо	44	51	45	88	(6)
12	Цалингийн сан	774,695,300	1,013,502,100	827,554,625	82	(185,947,475)
13	Нэг ажилтаны дундаж цалин	1,427,170	1,631,000	1,532,509	94	(98,491)

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	78,052,800.00	77,664,398.45	1,585,552,939.76	183,703,792.46	1,924,973,930.67
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	10,172,530.16	10,172,530.16
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдэлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
9	2024 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	78,052,800.00	77,664,398.45	1,585,552,939.76	193,876,322.62	1,935,146,460.83
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(571,136,275.14)	(571,136,275.14)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	(8,954,000)	(8,954,000)
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	(1,525,880.00)	(1,525,880.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдэлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
17	2025 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	78,052,800.00	77,664,398.45	1,585,552,939.76	(378,785,832.52)	1,353,530,305.69

Гурав. Аудитын илрүүлэлт: Аудитаар нийт 577,095.6 мянган төгрөгийн материаллаг бус зөрчил илэрч баталгаажуулав.

Материаллаг зөрчил гараагүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 577.095,6 мянган төгрөгийн 5 зөрчил¹ илэрснээс алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ховд АЗЗА ТӨХК	-	-	-	-			-	-				
Дүн	-	-	-	-			-	-				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ховд АЗЗА ТӨХК	5	577,0					5	577,0				
Дүн	5	577,0					5	577,0				

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТӨҮГ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			